

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/131/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70592225

Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр

Утас: 70593113

Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Л.Баянмөнх

Утас: 99997540

Цахим хаяг: bayanmunkhamina@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

_____ № _____
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙХАН-ОВОО СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Н.БАДАМЦЭЦЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Дундговь аймгийн Сайхан овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар албан хаагч нарын ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлж, дүгнээгүй мөнгөн урамшууллыг 60 хувиар тооцож 11.6 сая төгрөгийг хавтгайруулан олгосон зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-т /*байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох*/, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3.9-т /*Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг тухайн ажилтны ажиллаж байгаа тасаг, нэгжийн дарга үнэлж, хамт олны хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргана*/, 3.10-т /*Эрүүл мэндийн байгууллагын тасаг, нэгжийн хамт олны хурлаас гаргасан дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшил олгох шийдвэрийг байгууллагын дарга гаргана*/ заасныг тус тус зөрчсөн байна.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаанууд нь урьдчилан тооцоолсон материаллаг

4825020170

байдлын түвшнээс 2.3 дахин их, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох заавар журмын заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 112.2 сая төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилт, 6 арга хэмжээг хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 87.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	95,200,709.14	214,899,290.73
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30,514,268.32	40,458,704.70
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	30,514,268.32	40,458,704.70
3121	Төгрөг	30,514,268.32	40,458,704.70
31211	Төрийн сангийн харилцах	24,847,525.59	34,791,961.97
31218	Ахмадын сангийн харилцах	5,666,742.73	5,666,742.73
33	АВЛАГА	3,019,359.86	98,173,557.31
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	412,595.92	157,818.14
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,335,211.00	97,744,186.23
335	Бусад авлага	271,552.94	271,552.94
33510	Байгууллагаас авах авлага	271,552.94	271,552.94
35	БАРАА МАТЕРИАЛ	61,667,080.96	76,267,028.72
351	Түүхий эд материал	43,218,734.98	49,830,052.74
35110	Тусгай зориулалттай материал	32,244,062.78	37,711,029.37
35130	Эм боох материал	10,974,672.20	12,119,023.37
354	Хангамжийн материал	18,448,345.98	26,436,975.98
35410	Бичиг хэргийн материал	367,600.00	432,500.00
35420	Аж ахуйн материал	16,477,615.98	16,784,615.98
35450	Барилгын засварын материал	1,300,000.00	8,256,400.00
35460	Хүнсний материал	303,130.00	963,460.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	489,550,417.43	579,023,328.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	489,550,417.43	579,023,328.61
392	Биет хөрөнгө	478,606,417.43	568,079,328.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	415,585,839.40	415,585,839.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	(64,945,264.48)	(77,503,975.27)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	32,000,000.00	101,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,437,500.00)	(29,017,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	193,112,948.55	221,310,515.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	(86,308,712.52)	(73,413,431.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,113,219.00	16,388,219.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,514,112.52)	(6,670,339.07)
393	Биет бус хөрөнгө	10,944,000.00	10,944,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,944,000.00	10,944,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	584,751,126.57	793,922,619.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,492,030.00	27,483,583.91
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,492,030.00	27,483,583.91
413	Өглөг	10,492,030.00	27,483,583.91
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	27,473.00	905,539.47
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	10,273,729.00	26,578,044.44
4136	Бусад өглөг	190,828.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	190,828.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	574,259,096.57	766,439,035.43
51	Засгийн газрын хувь оролцоо	574,259,096.57	766,439,035.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	538,511,783.69	538,511,783.69
51101	Өмч: - төрийн	538,511,783.69	538,511,783.69
512	Хуримтлагдсан үр дүн	(84,295,435.15)	107,884,503.71
51210	Өмнөх үеийн үр дүн	(19,996,653.23)	(84,888,420.96)
51220	Тайлант үеийн үр дүн	(64,298,781.92)	192,772,924.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	120,042,748.03	120,042,748.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	584,751,126.57	793,922,619.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	527,727,104.30	875,874,698.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,927,535.55	185,040,403.59
120	Нийтлэг татварын бус орлого	63,927,535.55	185,040,403.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	237,600.00	2,549,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	237,600.00	2,549,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	42,528,771.70	165,806,083.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	21,161,163.85	16,684,620.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	463,799,568.75	690,834,295.28
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,430,800.00	60,174,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,430,800.00	60,174,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	419,368,768.75	630,660,095.28
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	419,368,768.75	630,660,095.28
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	584,969,886.22	683,101,774.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	584,969,886.22	683,101,774.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	584,389,941.62	682,865,651.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,999,610.18	419,212,805.20
210101	Үндсэн цалин	215,658,487.16	254,557,726.00
210102	Нэмэгдэл	62,198,756.02	125,516,789.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,664,000.00	3,510,000.00
210104	Урамшуулал	26,478,367.00	35,628,290.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,023,638.94	50,731,424.66
210201	Тэтгэврийн даатгал	25,883,642.95	34,990,055.67
210202	Тэтгэмжийн даатгал	3,069,996.09	4,213,490.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,455,996.91	2,658,547.39
210204	Ажилгүйдлийн даатгал	601,262.15	1,799,500.28
210205	Эрүүл мэндийн даатгал	6,012,740.84	7,069,830.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,241,444.40	50,183,897.00
210301	Гэрэл, цахилгаан	3,353,805.40	2,764,707.00
210302	Түлш, халаалт	42,887,639.00	47,419,190.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,046,128.75	26,924,123.50
210401	Бичиг хэрэг	551,200.00	586,500.00
210402	Тээвэр, шатахуун	20,444,260.00	23,308,206.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	521,400.00	782,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	153,600.00	345,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,061,400.00	1,901,617.50
210408	Бараа материал акталсны зардал	20,314,268.75	-
2105	Нормативт зардал	44,967,599.21	42,763,668.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,061,604.21	38,519,713.43
210502	Хоол, хүнс	4,905,995.00	4,243,955.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,537,300.00	2,142,770.00
210604	Урсгал засвар	6,537,300.00	2,142,770.00
2107	Томилолт, зочны зардал	8,632,000.00	12,190,000.00
210702	Дотоод албан томилолт	8,632,000.00	12,190,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,445,481.00	1,410,576.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,500.00	44,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,000.00	96,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,705.00	33,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	228,000.00
210807	Газрын төлбөр	43,776.00	43,776.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	42,500.00	212,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,496,739.14	77,306,386.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,423,370.00	1,566,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	70,073,369.14	75,740,186.41

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	579,944.60	236,123.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	579,944.60	236,123.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	579,944.60	236,123.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(57,242,781.92)	192,772,924.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,056,000.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,056,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(7,056,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(64,298,781.92)	192,772,924.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	461,701,957.75	597,975,020.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	237,600.00	2,549,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	237,600.00	2,549,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	237,600.00	2,549,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	237,600.00	2,549,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	461,464,357.75	595,425,320.05
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,430,800.00	60,174,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,430,800.00	60,174,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	417,033,557.75	535,251,120.05
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	417,033,557.75	535,251,120.05
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	461,713,887.54	588,030,583.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	461,713,887.54	588,030,583.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	461,133,942.94	587,794,460.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,781,309.18	418,270,788.70
210101	Үндсэн цалин	219,581,945.04	253,615,709.50
210102	Нэмэгдэл	59,270,742.14	125,516,789.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,657,000.00	3,510,000.00
210104	Урамшуулал	26,271,622.00	35,628,290.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,436,234.86	50,731,424.91
210201	Тэтгэврийн даатгал	25,082,065.87	34,990,055.32
210202	Тэтгэмжийн даатгал	3,069,996.09	4,213,491.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,455,996.91	2,658,547.39
210204	Ажилгүйдлийн даатгал	601,262.15	1,799,500.28
210205	Эрүүл мэндийн даатгал	7,226,913.84	7,069,830.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,084,555.40	52,438,907.00
210301	Гэрэл, цахилгаан	3,353,805.40	2,764,707.00
210302	Түлш, халаалт	34,730,750.00	49,674,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,888,460.00	21,843,022.50
210401	Бичиг хэрэг	504,300.00	437,900.00
210402	Тээвэр, шатахуун	20,343,060.00	18,618,105.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	521,400.00	782,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	249,600.00	195,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,270,100.00	1,809,217.50
2105	Нормативт зардал	30,951,102.50	28,482,107.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,959,430.00	23,865,572.00
210502	Хоол, хүнс	2,991,672.50	4,616,535.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,287,300.00	9,099,170.00
210604	Урсгал засвар	8,287,300.00	9,099,170.00
2107	Томилолт, зочны зардал	8,632,000.00	4,050,000.00
210702	Дотоод албан томилолт	8,632,000.00	4,050,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,445,481.00	1,312,840.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	98,500.00	44,000.00

	үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,000.00	96,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,705.00	33,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	228,000.00
210807	Газрын төлбөр	43,776.00	43,776.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	42,500.00	114,464.56
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,627,500.00	1,566,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,627,500.00	1,566,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	579,944.60	236,123.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	579,944.60	236,123.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	579,944.60	236,123.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(11,929.79)	9,944,436.38
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(11,929.79)	9,944,436.38
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	30,526,198.11	30,514,268.32
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,514,268.32	40,458,704.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	538,511,783.69	120,042,748.03	-19,996,653.23	638,557,878.49
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	538,511,783.69	120,042,748.03	-19,996,653.23	638,557,878.49
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-64,298,781.92	-64,298,781.92
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	538,511,783.69	120,042,748.03	-84,295,435.15	574,259,096.57
5	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	538,511,783.69	120,042,748.03	-84,295,435.15	574,259,096.57
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-592,985.81	-592,985.81
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	538,511,783.69	120,042,748.03	-84,888,420.96	573,666,110.76
8	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	192,772,924.67	192,772,924.67
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	538,511,783.69	120,042,748.03	107,884,503.71	766,439,035.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	728,978,000.00	587,794,460.67	141,183,539.33	80.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	728,978,000.00	587,794,460.67	141,183,539.33	80.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	728,978,000.00	587,794,460.67	141,183,539.33	80.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	521,271,300.00	418,270,788.70	103,000,511.30	80.2
210101	Үндсэн цалин	324,479,400.00	253,615,709.50	70,863,690.50	78.2
210102	Нэмэгдэл	141,000,000.00	125,516,789.20	15,483,210.80	89.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,010,000.00	3,510,000.00	2,500,000.00	58.4
210104	Урамшуулал	49,781,900.00	35,628,290.00	14,153,610.00	71.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,159,000.00	50,731,424.91	14,427,575.09	77.9

210201	Тэтгэврийн даатгал	44,308,100.00	34,990,055.32	9,318,044.68	79.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,212,700.00	4,213,491.52	999,208.48	80.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,606,400.00	2,658,547.39	(52,147.39)	102.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,606,400.00	1,799,500.28	806,899.72	69.0
210205	Эрүүл мэндийн даатгал	10,425,400.00	7,069,830.40	3,355,569.60	67.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,674,200.00	52,438,907.00	235,293.00	99.6
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,764,707.00	235,293.00	92.2
210302	Түлш, халаалт	49,674,200.00	49,674,200.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	33,592,700.00	21,843,022.50	11,749,677.50	65.0
210401	Бичиг хэрэг	1,137,400.00	437,900.00	699,500.00	38.5
210402	Тээвэр, шатахуун	28,151,500.00	18,618,105.00	9,533,395.00	66.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	898,500.00	782,100.00	116,400.00	87.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариугал	1,137,400.00	195,700.00	941,700.00	17.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,267,900.00	1,809,217.50	458,682.50	79.8
2105	Нормативт зардал	35,865,600.00	28,482,107.00	7,383,493.00	79.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,764,500.00	23,865,572.00	3,898,928.00	86.0
210502	Хоол, хүнс	8,101,100.00	4,616,535.00	3,484,565.00	57.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,300,000.00	9,099,170.00	200,830.00	97.8
210604	Урсгал засвар	9,300,000.00	9,099,170.00	200,830.00	97.8
2107	Томилолт, зочны зардал	6,830,800.00	4,050,000.00	2,780,800.00	59.3
210702	Дотоод албан томилолт	6,830,800.00	4,050,000.00	2,780,800.00	59.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,662,700.00	1,312,840.56	349,859.44	79.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,800.00	44,000.00	72,800.00	37.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	159,000.00	96,000.00	63,000.00	60.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,300.00	33,600.00	137,700.00	19.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	33,000.00	22,000.00	60.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	228,000.00	228,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	-	43,776.00	(43,776.00)	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	87,600.00	-	87,600.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	125,000.00	114,464.56	10,535.44	91.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,621,700.00	1,566,200.00	1,055,500.00	59.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,621,700.00	1,566,200.00	1,055,500.00	59.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	728,978,000.00	597,738,897.05	106,391,602.95	85.4
122	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	60,174,200.00	59,938,077.00	236,123.00	99.6
122005	Орон нутгийн төсвөөс	60,174,200.00	59,938,077.00	236,123.00	99.6
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	641,406,600.00	535,251,120.05	108,705,179.95	83.1
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	641,406,600.00	535,251,120.05	108,705,179.95	83.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	27,397,200.00	2,549,700.00	24,847,500.00	
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого туслах	2,549,700.00	2,549,700.00	-	100
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	24,847,500.00	-	24,847,500.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах	-	24,847,525.59	0	

	хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	34,791,961.97	(34,791,961.97)	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,056.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 617.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 15,439.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүллээ.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 15,439.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, зөрчил арилгах албан шаардлага хүргүүллээ.

3.1 АЛБАН ШААРДЛАГА

3.1.1 Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Байгууллагын нягтлан бодогч, эд хариуцагч нарын ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6.байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох. гэж заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Ажлын гүйцэтгэл үр дүнгээ үнэлж дүгнүүлээгүй ажилтнуудад ажлын үр дүнг харгалзахгүйгээр мөнгөн урамшууллыг 60 хувиар тооцож хавтгайруулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6.байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 3.9."Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг тухайн ажилтны ажиллаж байгаа тасаг, нэгжийн дарга үнэлж, хамт олны хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргана".3.10". Эрүүл мэндийн байгууллагын тасаг, нэгжийн хамт олны хурлаас гаргасан дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшил олгох шийдвэрийг байгууллагын дарга гаргана" гэж заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд Тусгай зориулалттай материалын дансанд Хүүхдийн зургийн хэрэгсэл, ном, тоглоом бүртгэж тайлагнасан.	1	2148					1	214.8				
Санхүүгийн үр дүнгийн тайланд Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж ангилалд мэдээлэл техниолого, маягт хэвлэх зардал зөрүүтэй бүртгэсэн	1	402.8					1	402.8				
Дүн	2	617.6					2	617.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Байгууллагын нягтлан бодогч, эд хариуцагч нарын ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон.	1	3,828.1			1	3,828.1						
Ажлын гүйцэтгэл үр дүнгээ үнэлж дүгнүүлээгүй ажилтнуудад ажлын үр дүнг харгалзахгүйгээр мөнгөн урамшууллыг 60 хувиар тооцож хавтгайруулж олгосон.	1	11,611.2			1	11,611.2						
Дүн	2	15,439.3	-	-	2	15,439.3	-	-	-	-	-	-

5.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		